



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/274

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 2020 оны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Чингис хот дахь бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үнэлж дүгнэх, зохион байгуулалтаар хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн
дарга

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

"Хэнтий-Ус" ХХК-ийн захирал

"БЗӨБЦТС" ТӨХК-ийн Хэнтий салбарын дарга

Хэнтий Политехникийн коллежийн захирал

2 Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гарааны бизнес, үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ